ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

# 2018/02




www.dundgovi.nso.mn

УТАС: 70593715, 70593714

**Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал**
**(2018 оны 2 сарын байдлаар)**

## I.Төсвийн орлого

Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2018 оны 2-р сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 36.7 хувьтай буюу 915.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 138.7 хувьтай буюу 148.7 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 1063.9 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 40.9 хувьтай байна.




Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 6740.8 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 81 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 1332.6 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 4306.2 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 186.7 нийт 5825.5 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

**Төсвийн орлогод эзлэх хувь 2018 оны 2 сарын байдлаар**




Орон нутгийн төсвийн орлогынхоо төлөвлөгөөг Баянжаргалан, Гурвансайхан, Өлзийт, Луус, Дэлгэрхангай, Сайнцагаан, Адаацаг сумд 9.8-49.2 хувиар буюу 1.7-25.6 сая төгрөгөөр төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн бол бусад сумд төлөвлөгөөгөө 4.5-27.2 хувиар тасалдуулсан байна.

## II.Төсвийн зарлага

2018 оны 2 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 5386.6 сая төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.2 хувиар буурсан байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 2908,4 сая төгрөг болж нийт зардлын 54 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 10.7 хувиар өсч 336.9 сая төгрөг болсон байна. Тухайн сарын байдлаар байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 805.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өссөн бол хангамжийн бараа материалын зардал, норматив зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал хөрөнгийн зардал өмнөх оны мөн үеэс өссөн бол норматив зардал, томилолтын зардал засгийн газрын дотоод шилжүүлэг, бусад урсгал шилжүүлэг 6.4-95 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

## III.Банк

Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар өсч 102080.7 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 1004.8 сая төгрөг, чанаргүй зээл 623.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 13.8 хувиар буурч, чанаргүй зээл 0.4 хувиар өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 1,6 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн хувийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 23.2 хувиар өсч 39474.3 сая төгрөг болов.




## IV.Бүртгэлтэй ажилгүйчүүд

2018 оны 2 сарын байдлаар аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил хайж байгаа 691 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 352 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 46.7 хувь буюу 323 хүн нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 226 ажилгүйчүүд ногдож байхад Баянжаргалан 410, Сайнцагаан 362, Дэлгэрцогт суманд /298/, Өндөршил /339/ байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна.




Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 20.0 хувь нь дипломын болон баклаврын дээд, 3.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 9.0 хувь нь техникийн болон мэргэжлийн, 35.0 хувь нь бүрэн дунд, 22.0 хувь нь суурь, 9.0 хувь нь бага, 2.0 хувь нь боловсролгүй

иргэд байна.Нийт бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 2,2 хувь буюу 15 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа бол 50,8 хувь нь 15-34 насны залуучууд байна.




## V.Ажлын байрны зуучлал

Хөдөлмөрийн хэлтсийн 2018 оны 2 сарын мэдээгээр нийт 132 хүн ажлын байранд зуучлагдсан нь өмнөх оны мөн үеэс 76 хүнээр нэмэгдсэн байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд удирлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 38,6 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 50,8 хувь, Төрийн удирдлага батлан хамгаалахын салбарт 3,0 хувь, боловсролын салбар, санхүү даатгалын салбарт тус бүр 2,3 хувь нь зуучлагдсан бол үлдсэн хувь нь уул уурхай, эрүүл мэнд, урлаг соёлын салбарт зуучлагджээ.




сарын
...х оны
мөн үеийнхээс орлого 143.1 сая төгрөгөөр буурч, зарлага 175 сая төгрөг буюу 4.1 хувиар өслөө.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд 2018 оны эхний 2 сарын байдлаар 7895 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 1617 хүн буюу 20.5 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 3534 хүн буюу 44.8 хувь нь төсөвт байгууллагаас, 2744 хүн буюу 34.7 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүгд буурсан байна.




Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2018 оны эхний 2 сарын байдлаар 3961.6 сая төг болж, үүний 81.7 хувийг өндөр настны, 12.3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.7 хувийг тэжээгчээ алдсаны, 3.3 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Энэ оны эхний 2 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 6639 хүн байна. Нийт тэтгэвэр авагчдын 80.7 хувь буюу 5356 хүн өндөр насны, 14.0 хувь буюу 931 хүн тахир дутуугийн, 3.5 хувь буюу 234 хүн тэжээгчээ алдсаны, 1.8 хувь буюу 118 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

**Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо, жил бүрийн эхний 2 сарын байдлаар**




Энэ оны эхний 2 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 419, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 22 ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 36 хүн байна.

Эхний 2 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 11236 байгаагийн 79.8 хувь буюу 8967 төр хариуцах иргэд, 12.4 хувь буюу 1392 малчид, 7.8 хувь буюу 877 оюутан суралцагсад, аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн байна.

2018 оны 2 сарын байдлаар аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 1651.6 сая төгрөг болж төлөвлөгөөгөө 33.2 хувиар буюу 441.2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөгөө Гурвансайхан сумаас бусад бүх сумд давуулан биелүүлсэн байна.

## VII. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2018 оны 2-р сарын байдлаар 154 эх төрсөн нь өнгөрсөн мөн үеэс 20 төрөлтөөр өссөн ба нийт 155 хүүхэд амьд төрсөн байна. Төрсөн эхчүүдийн 90,3 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ сарын байдлаар эхийн эндэгдэл гараагүй.

**Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 2 сарын байдлаар**



2018 оны 2 сарын  байдлаар 1 хүртлэх насны нялхсын эндэгдэл 2 байгаа нь Дэлгэрцогт сум болон аймгийн нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн байна. Нас баралтын 42 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 3 тохиолдлоор өсчээ. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт хамгийн өндөр 26,2 хувийг эзэлж байна.

Тухайн сарын  байдлаар стационарит шинээр 1976 эмчлүүлэгч хэвтэж, 1996 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт  14521 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.3 байна. 2018 оны 2 сарын байдлаар 25622 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 20,0 %, амбулаторийн үзлэг 53,4%, идэвхитэй хяналт 17,1 %, гэрийн үзлэг 5,7 %- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 34,2 хувь нь эрэгтэй, 65,8 хувь нь эмэгтэй хүн байна.




Халдварт өвчний  74 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үеэс 3 тохиолдлоор буурч, 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 16,1 болж өмнөх оны мөн үеэс 0,9 хувиар буурсан байна.

## YIII. Нийгмийн халамж

2018 оны эхний 2 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 9699 хүнд 1170,6 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна. Нийт тэтгэвэр тэтгэмж авагчидын 35% буюу 3443 нь алдарт эхийн одонтой эхчүүд бөгөөд 487,3 сая төг, 23.0 % буюу 2212 нь насны хишиг тэтгэмж авч буй ахмадууд 202,6 сая төг, 20% буюу 1930 нь 0-3 насны хүүхдээ асарч буй эхчүүдэд 117,6 сая төг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 738 иргэн 87,9 сая төгрөг, Халамжийн тэтгэвэрийг 721 иргэн 197,2 сая төгрөг, жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй 395 эхчүүдэд 23,6 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг олгосон байна.

## IX. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхийнхийг биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2018 оны 2-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2017 оны 2-р сартай харьцуулахад 5.2 хувиар өсчээ.

Хэрэглээний үнийн индекс 5.2 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 9.0 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 9.9 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 0.7 хувь өссөн, орон сууц, ус , цахилгаан, түлшний бүлэг 0.6 хувь буурсан, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 7.0 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 8.4, тээврийн бүлэг 13.8 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.




2018 оны 2 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин , дизель түлш болон ноолуурын үнийг оруууллаа.

ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/

| № | Барааны нэр, төрөл | II/07 | II/14 | II/21 | II/28 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гурил, 1-р зэрэг, кг | 1200 | 1200 | 1200 | 1216 |
| 2 | Хонины мах, кг | 5500 | 5500 | 5500 | 5500 |
| 3 | Үхрийн мах, кг | 0 | 0 | 0 | 0 |
| 4 | Ямааны ястай мах, кг | 4500 | 4500 | 4000 | 4500 |
| 5 | Элсэн чихэр, кг | 2000 | 2000 | 2000 | 2000 |
| 6 | Цагаан будаа, кг | 2266 | 2266 | 2283 | 2283 |
| 7 | Шингэн сүү, л | 3000 | 3000 | 3000 | 3000 |
| 8 | Ноолуурын үнэ 1 кг | 70000 | 70000 | 70000 | 70000 |
| 9 | Бензин А-80, 1литр | 1630 | 1640 | 1666 | 1666 |
| 10 | Бензин А-92, 1литр | 1780 | 1790 | 1790 | 1790 |
| 11 | Дизель түлш 1 литр | 2097 | 2120 | 2126 | 2126 |

## X. Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд энэ оны 3 сарын 1 ны байдлаар 3556 толгой мал хорогдоод байна. Үүний 8.4 хувь буюу 300 адуу, 13.6 хувь буюу 483 үхэр, 27.6 хувь 983 ямаа, 50,2 хувь буюу 1786 хувийг хонь эзэлж байна.

## XI. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2018 оны 2 сарын байдлаар 1298.7 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 7 хувиар буурсан байна.



## XII. Гэмт хэрэг

Цагдаагийн хэлтсийн 2018 оны эхний 2 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 43 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна. Гэмт хэрэгт холбогдогсдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 87,2 хувиар буурч, 5 хүн холбогдоод байна. 2018 оны эхний 2 сарын байдлаар танхайрах, булаалт, дээрэм , албан тушаал, гал түймэрийн гэмт хэрэг гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс хүн амины ,бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг, бусдын эд хөрөнгийг хулгайлах, золгүй учрал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэргүүд нэмэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл 41,8 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг, 25,5 хувийг хулгайн, 13,9 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг, 2,3 хувийг хүн амины, 2,3 хувийг хүчиндэх, 2,3 хувийг золгүй учралын хэрэг тус тус эзэлж байна.

Нийт гэмт хэргийн 6,9 хувийг согтуугаар үйлдсэн байна. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг аймгийн дүн 8 хүн байхад Дэлгэрцогт 9, , Сайнцагаан 18, ,Өндөршил 10 байгаа нь гэмт хэрэг ихтэй сумдад орж байна.




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 86,8 сая төгрөг, түүний 4,8 хувь буюу 4,2 сая төгрөгийг нөхөн төлүүлээд байна. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 51,1 хувиар буурч 11,9 болсон байна

## XIII. Байгаль орчин

ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Энэ сард агаарын дундаж температур нь нийт нутгаар 5-10 градус хүйтэн байдаг ба олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар дулаан байна. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхээр бага зэрэг хүйтэрч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 19-24 градус, өдөртөө 3-8 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 13-18 градус хүйтэн, өдөртөө 1-6 градус дулаан байна. Нэг болон хоёрдугаар арав хоногийн сүүлчээр хүйтний эрч суларч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 6-11 градус хүйтэн, өдөртөө 1 градус дулаанаас 4 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 7-12 градус хүйтэн, өдөртөө 9-14 градус

дулаан байна. Харин гуравдугаар арав хоногт дулаарч шөнөдөө нутгийн хойд хэсгээр 0-5 градус хүйтэн, бусад нутгаар 2 градус дулаанаас 3 градус хүйтэн, өдөртөө 16-21 градус дулаан байна.

Энэ сард нийт нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй.Хоёрдугаар арав хоногийн эхээр нутгийн өмнөд хэсгээр, сүүлээр зарим газраар бага зэргийн цас, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар хур тунадас орох төлөвтэй.Нэг болон хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлээр зарим газраар 12-14 м/с, зарим үед 16-18м/с, хоёр болон гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар 16-18 м/с, зарим үед 20-22 м/с хүртэл ширүүсч шороон ба цасан шуурга шуурах төлөвтэй.

# I.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, мянган төгрөгөөр

2018.03.12

| Үзүүлэлт | мөр | 2017 II | 2018 II | | | 18/17 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төл | гүйц | хувь | хувь |
| Нийт орлого /тусламжийн дүн/ | 1 | 6606049.5 | 8321291.8 | 6740798.9 | 81.0 | 102.0 |
| А.УРСГАЛ ОРЛОГО | 2 | 851579.4 | 2486746.2 | 903502.8 | 36.3 | 106.1 |
| I.ТАТВАРЫН ОРЛОГО | 3 | 514672.5 | 679026.1 | 569135.1 | 83.8 | 110.6 |
| 1.1 Хүн амын орлогын албан татвар | 4 | 474809.4 | 640683.8 | 518427.0 | 80.9 | 109.2 |
| 1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар | | 425034.5 | 547988.0 | 401387.8 | 73.2 | 94.4 |
| Хувь хүний орлогын албан татварын буцаалт | | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 1.2 үйл ажиллагааны орлого | 5 | 40932.4 | 33074.4 | 76137.1 | 0.0 | 0.0 |
| 1.3 Хөрөнгө борлуулсаны | 6 | 8842.5 | 5000.0 | 5994.7 | 0.0 | 0.0 |
| 1.4 Орлогыг нь тодорхойлох боломжгүй иргэний | 7 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | #DIV/0! |
| 1.5 Бусад татвар | 8 | 0.0 | 54621.4 | 34907.4 | 0.0 | 0.0 |
| 2.Хөрөнгийн татвар/ҮХХболон буу/ | 9 | 4379.6 | 6736.0 | 8069.9 | 119.8 | 184.3 |
| 3. Авто тээврийн хэрэгслийн | 12 | 5772.4 | 1000.0 | 5035.7 | 0.0 | 87.2 |
| 4. Бусад татвар | 13 | 29711.1 | 30606.3 | 37602.5 | 122.9 | 126.6 |
| 4.1 Улсын тэмдэгтийн | 14 | 17214.7 | 19080.6 | 26115.6 | 136.9 | 151.7 |
| 4.2 Ашигт малтмал нөөцийн | 15 | 90.9 | 0 | 56.8 | #DIV/0! | 62.5 |
| 4.3 Газрын төлбөр | 16 | 7685.5 | 9021.3 | 7810.7 | 86.6 | 101.6 |
| 4.5 Хог хаягдалын үйлчилгээний | 17 | 1438.2 | 2264.4 | 1110.8 | 49.1 | 0.0 |
| 4.6 Усны төлбөр | 18 | 0.0 | 200.0 | 1939.7 | 0.0 | 0.0 |
| 4.7 Лицензийн төлбөр | 19 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 4.6.Бусад | 20 | 3281.8 | 40.0 | 568.9 | 0.0 | 17.3 |
| II.ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 19 | 336906.9 | 1807720.1 | 334367.7 | 18.5 | 101.6 |
| 2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого | 22 | 300659.2 | 1755162.5 | 261210.2 | 14.9 | 86.9 |
| 2.2 Бусад нэр заагдаагүй | 23 | 36247.7 | 52557.6 | 73157.5 | 139.2 | 201.8 |
| Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО | 24 | 8355.0 | 9000.0 | 11750.5 | 0.0 | 0.0 |
| В.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО | 26 | 5746115.1 | 5825545.6 | 5825545.6 | 100.0 | 101.4 |
| 1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг | 28 | 1339277.8 | 1332620.8 | 1332620.8 | 0.0 | 99.5 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | 4276268.3 | 4306234.8 | 4306234.8 | 100.0 | 100.7 |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих | | 130569.0 | 186690.0 | 186690 | 100.0 | 0.0 |
| Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй / | 29 | 859934.4 | 2495746.2 | 915253.3 | 36.7 | 106.4 |
| Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого | 30 | 156531.0 | 107226.4 | 148674.4 | 138.7 | 95.0 |
| Аймгийн нийт орлого | 31 | 1016465.4 | 2602972.6 | 1063927.7 | 40.9 | 104.7 |

## II. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

2018.03.12

| Сумд | 2018 I-II | | | 2018 II сар | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө | гүйцэтгэл | хувь | төлөвлөгөө | гүйцэтгэл | хувь |
| Дэлгэрцогт | 15169.1 | 11205.2 | 73.9 | 7690.0 | 6267.9 | 81.5 |
| Дэрэн | 13090.0 | 16175.0 | 123.6 | 6500.0 | 8578.6 | 132.0 |
| Говь-Угтаал | 19990.0 | 15894.2 | 79.5 | 8220.0 | 7631.3 | 92.8 |
| Цагаандэлгэр | 10864.4 | 9559.5 | 88.0 | 5590.0 | 7758.3 | 138.8 |
| Баянжаргалан | 46027.6 | 50911.3 | 110.6 | 18360.0 | 24601.4 | 134.0 |
| Өндөршил | 15317.8 | 13790.2 | 90.0 | 7733.9 | 5155.6 | 66.7 |
| Гурвансайхан | 25241.5 | 37472.8 | 148.5 | 13566.5 | 16949.7 | 124.9 |
| Өлзийт | 16868.0 | 19416.1 | 115.1 | 8380.0 | 8361.3 | 99.8 |
| Хулд | 30410.0 | 26935.1 | 88.6 | 16555.0 | 16178.2 | 97.7 |
| Луус | 13027.0 | 18828.6 | 144.5 | 7008.0 | 8230.6 | 117.4 |
| Дэлгэрхангай | 17304.3 | 19007.2 | 109.8 | 9126.3 | 7798.1 | 85.4 |
| Сайхан-Овоо | 15750.0 | 11470.3 | 72.8 | 8085.0 | 4604.1 | 56.9 |
| Эрдэнэдалай | 35794.0 | 34194.9 | 95.5 | 17844.0 | 17455.3 | 97.8 |
| Сайнцагаан | 55980.0 | 83548.4 | 149.2 | 33580.0 | 34460.8 | 102.6 |
| Адаацаг | 15060.0 | 17458.3 | 115.9 | 7870.0 | 7052.8 | 89.6 |
| Дундговь | 506712.4 | 465202.7 | 91.8 | 269488.0 | 287987.1 | 106.9 |
| Дүн | 852606.1 | 851069.8 | 99.8 | 445596.7 | 469071.1 | 105.3 |

# IV.БАНКНЫ КАССЫН ОРЛОГО, ЗАРЛАГА, ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН МЭДЭЭ, сар бүрийн эцэст, сая төгрөгөөр

2018.03.12

| № | Үзүүлэлт | | ХААН банк | | Хас банк | | Төрийн банк | | Капитал банк | | Бүгд | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2017 II | 2018 II | 2017 II | 2018 II | 2017 II | 2018 II | 2017 II | 2018 II | 2017 II | 2018 II | 2018/2017 хувь |
| 1 | Кассын орлого | Зузаатгалаар | 1,730.00 | 1,742.40 | 155.3 | 291.8 | 2814.8 | 2042.2 | 0.0 | 0.0 | 4700.1 | 4076.4 | 86.7 |
| | Кассын зарлага | шилжүүлсэн | 1,334.80 | 2,352.10 | 448.7 | 602.1 | 10.6 | 407.1 | 35.0 | 0.0 | 1829.1 | 3361.3 | 183.8 |
| 2 | Зээлийн өрийн үлдэгдэл | | 57569.6 | 61137.6 | 9924.1 | 11024.9 | 23541.3 | 29894.1 | 152.7 | 24.0 | 91187.7 | 102080.6 | 111.9 |
| 3 | үүнээс: Анхаарал хандуулах зээл | | 455.4 | 293.6 | 680.0 | 643.6 | 30.8 | 67.7 | 0.0 | 0.0 | 1166.2 | 1004.9 | 86.2 |
| | чанаргүй зээл | | 322.4 | 334.8 | 193.7 | 221.9 | 76.0 | 47.8 | 29.1 | 18.9 | 621.2 | 623.4 | 100.4 |
| 4 | Иргэдийн хувийн хадгаламжийн үлдэгдэл | | 20568.7 | 24657.4 | 3818.8 | 4301.4 | 7506.4 | 10195.2 | 149.6 | 320.3 | 32043.5 | 39474.3 | 123.2 |

III.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

2018.03.12

| Зарлагын төрөл | 2017 II | 2018 II | | | 2018 II /2017 II |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | |
| Орон нутгийн байгууллагын зарлагын дүн | 6133886.7 | 9854442.5 | 5386332.3 | 54.7 | 87.8 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2896196.0 | 3072535.2 | 2908379.5 | 94.7 | 100.4 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 304359.1 | 370182.7 | 336921.0 | 94.7 | 110.7 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 753480.6 | 999936.2 | 805326.1 | 91.0 | 106.9 |
| Хангамж бараа материалын зардал | 59574.4 | 135741.7 | 64302.2 | 47.4 | 107.9 |
| Норматив зардал | 202392.1 | 332300.3 | 142150.8 | 42.8 | 70.2 |
| Эд хогшил урсгал засварын зардал | 9780.1 | 58668.8 | 17741.5 | 30.2 | 181.4 |
| Томилолтын зардал | 14494.3 | 29105.0 | 13566.2 | 46.6 | 93.6 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 66610.3 | 165707.2 | 67123.9 | 40.5 | 100.8 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 172429.5 | 3043564.7 | 244087.0 | 8.0 | 141.6 |
| Засгийн газрын дотоод шилжүүлэг | 682332.1 | 33960.4 | 33960.4 | 100.0 | 5.0 |
| Бусад урсгал шилжүүлэг | 938629.8 | 941379.0 | 519276.7 | 55.2 | 55.3 |
| Хөрөнгийн зардал | 33608.4 | 671361.3 | 233497 | 34.8 | 694.8 |

## V.АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

2018.03.12

| Сум | Оны эхний | Тайлант сарын | Тайлант сарын | Үүнээс | Хөдөлмөрийн |
|---|---|---|---|---|---|
| Дэлгэрцогт | 1,106.0 | 33.0 | 33.0 | 7.0 | 298 |
| Дэрэн | 1,363.0 | 11.0 | 17.0 | 6.0 | 125 |
| Говь-Угтаал | 1,068.0 | 53.0 | 17.0 | 4.0 | 159 |
| Цагаандэлгэр | 694.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0 |
| Баянжаргалан | 756.0 | 42.0 | 31.0 | 5.0 | 410 |
| Өндөршил | 973.0 | 50.0 | 33.0 | 4.0 | 339 |
| Гурвансайхан | 1,449.0 | 7.0 | 6.0 | 2.0 | 41 |
| Өлзийт | 1,607.0 | 29.0 | 20.0 | 9.0 | 124 |
| Хулд | 1,612.0 | 27.0 | 20.0 | 9.0 | 124 |
| Луус | 1,239.0 | 20.0 | 17.0 | 4.0 | 137 |
| Дэлгэрхангай | 1,489.0 | 21.0 | 8.0 | 4.0 | 54 |
| Сайхан-Овоо | 1,470.0 | 31.0 | 17.0 | 4.0 | 116 |
| Эрдэнэдалай | 3,685.0 | 92.0 | 65.0 | 34.0 | 176 |
| Сайнцагаан | 10,074.0 | 379.0 | 365.0 | 214.0 | 362 |
| Адаацаг | 1,943.0 | 45.0 | 42.0 | 17.0 | 216 |
| Дүн | 30528 | 840 | 691 | 323 | 226 |

## YI. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2018 оны эхний 2 сарын байдлаар

2018.03.12

| Эдийн засгийн салбарын ангилал | Ажилд зуучилсан иргэд | үүнээс: эмэгтэй | Эдийн засгийн салбарын эзлэх хувь |
|---|---|---|---|
| ХАА, ан агнуур, ойн аж ахуй | 0.0 | 0.0 | 0.0 |
| Уул уурхай олборлох үйлдвэр | 1.0 | 1.0 | 0.8 |
| Боловсруулах аж  үйлдвэр | 0.0 | 0.0 | 0.0 |
| Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт | 0.0 | 0.0 | 0.0 |
| Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог | 0.0 | 0.0 | 0.0 |
| Барилга | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бөөний ба жижиглэн худалдаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Зочид буудал, зоогийн газар | 0.0 | 0.0 | 0.0 |
| Мэдээлэл холбоо | 0.0 | 0.0 | 0.0 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 3.0 | 3.0 | 2.3 |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 51.0 | 17.0 | 38.6 |
| Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа | 4.0 | 3.0 | 3.0 |
| Боловсрол | 4.0 | 3.0 | 3.0 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 1.0 | 1.0 | 0.8 |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам | 1.0 | 1.0 | 0.8 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 67.0 | 5.0 | 50.8 |
| Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бүгд | 132.0 | 34.0 | 100.0 |

## VII. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН МЭДЭЭ 2018 оны 2-р сар

2018.03.12

| Халамжийн төрүүд | хамрагдсан хүн | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **Халамжийн тэтгэвэр** | **721** | **197,168.70** |
| **Нөхцөлт мөнгөн тэтгэмж** | **738.00** | **87,877.90** |
| *Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч* | 436 | 50,900.70 |
| *Байнгын асаргаа шаардлагатай ХБ хүүхдийг асарч байгаа* | 146 | 16,639.50 |
| *Бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж харгалзан дэмжигчид* | 21 | 3,318.10 |
| *Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа* | 11 | 2,144.00 |
| *Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа* | 1 | 134.00 |
| *Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа* | 123 | 14,741.60 |
| **Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн** | **395** | **23,568.50** |
| **Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн** | **0.00** | **0.00** |
| **Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай** | **152** | **36,697.60** |
| *Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн цэцэрлэгийн хоолны үнийн хөнгөлөлт* | 0 | 0.00 |
| *16 хүрэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд* | 149 | 35,377.60 |
| *3 хүртэлхи насны ихэр хүүхдэд жилд нэг удаа* | | |
| *Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улирал нэг удаа* | 2 | 120.00 |
| *3 ба түүнээс дээш тооны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд нэг удаа* | 0 | 0.00 |
| *18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны* | 0 | 0.00 |
| *Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд нэг* | 1 | 1,200.00 |
| **0-03 насны хүүхэд асарсны тэтгэмж** | **1930** | **117,610.30** |
| **Өрх толгойлсон эцэг, эх** | **0** | **0.00** |
| **Хүнс тэжээл нийгмийн хамгаалалын хөтөлбөрт** | **0** | **0.00** |
| **Насны хишиг** | **2212** | **202,570.00** |
| **Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж** | **3443** | **487,300.00** |
| **Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж** | **48** | **7,444.50** |
| **Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж/** | **35** | **3,686.00** |
| **Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж,** | **25** | **6,600.00** |
| **Зарлагын нийт дүн** | **9,699** | **1,170,523.50** |

## VIII. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА /сая.төг/

2018.03.12

| | 2017 оны II сар | 2018 оны II сар | | | 2018 II / 2017 II хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | |
| Нийгмийн даатгалын сангийн орлого | 4606.2 | 1240.3 | 4463.1 | 359.8 | 96.9 |
| Үүнээс | | | | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 3782.8 | 1035.2 | 3913.2 | 378.0 | 103.4 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 199.6 | 111.8 | 172.1 | 153.9 | 86.2 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | 434.5 | 0.0 | 261.9 | 0.0 | 60.3 |
| ҮОМШӨ*-ний даатгалын сангийн | 84.3 | 73.0 | 65.5 | 89.7 | 77.7 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 105.0 | 20.3 | 50.4 | 248.3 | 48.0 |
| Нийгмийн даатгалын сангийн зарлага | 4313.6 | 4518.2 | 4488.6 | 99.3 | 104.1 |
| Үүнээс | | | | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 3639.1 | 4187.5 | 3976.2 | 95.0 | 109.3 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 171.2 | 193.2 | 194.3 | 100.6 | 113.5 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | 367.4 | 0.0 | 265.4 | 0.0 | 72.2 |
| ҮОМШӨ*-ний даатгалын сангийн | 64.4 | 76.2 | 14.6 | 19.2 | 22.7 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 71.5 | 61.3 | 38.1 | 62.2 | 53.3 |

Тайлбар: *Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

## IX. НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧИЙН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭРИЙН ХЭМЖЭЭ

2018.03.12

| Үзүүлэлтүүд | 2016 оны II сар | 2017 оны II сар | 2018 оны II сар | 2018 II 2017 II хувь |
|---|---|---|---|---|
| Заавал даатгуулагчийн тоо | 6784 | 6300 | 7895 | 125.3 |
| Үүнээс: | | | | |
| Аж ахуй нэгж, байгууллага | 1666 | 1651 | 1617 | 97.9 |
| Төсөвт байгууллага | 3546 | 3507 | 3534 | 100.8 |
| Сайн дурын | 1572 | 1142 | 2744 | 240.3 |
| Олгосон тэтгэвэр, сая.төг | 3315.0 | 3652.1 | 3961.6 | 108.5 |
| Үүнээс: | | | | |
| Өндөр настны | 2701.4 | 3114.0 | 3238.3 | 104.0 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн | 422.7 | 372.7 | 487.9 | 130.9 |
| Тэжээгчээ алдсаны | 98.3 | 101.0 | 109.0 | 107.9 |
| Цэргийн | 92.6 | 64.4 | 126.4 | 196.3 |

## X. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЭКС

2018.03.12

| Барааны бүлгээр | 2018 II / 2017 II | 2018 II / 2017 XII |
|---|---|---|
| ЕРӨНХИЙ ИНДЭКС | 105.2 | 102.1 |
| 01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА | 109.0 | 104.9 |
| 01.1 ХҮНСНИЙ БАРАА | 108.6 | 105.2 |
| 01.1.1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА | 101.2 | 101.0 |
| 01.1.2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН | 108.5 | 123.2 |
| 01.1.3 ЗАГАС, ДАЛАЙН БҮТЭЭГДЭХҮҮН | 130.4 | 100.0 |
| 01.1.4 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ | 111.4 | 104.5 |
| 01.1.5 ТӨРӨЛ БҮРИЙН ӨӨХ, ТОС | 100.1 | 96.6 |
| 01.1.6 ЖИМС, ЖИМСГЭНЭ | 148.2 | 100.2 |
| 01.1.7 ХҮНСНИЙ НОГОО | 108.0 | 104.3 |
| 01.1.8 СААХАР, ЖИМСНИЙ ЧАНАМАЛ, ЗӨГИЙН БАЛ, ЧИХЭР | 103.1 | 101.2 |
| 01.1.9 ХҮНСНИЙ БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН | 113.6 | 101.0 |
| 01.2 СОГТУУРУУЛАХ БУС УНДАА | 113.1 | 101.5 |
| 02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС | 109.9 | 105.0 |
| 02.1 СОГТУУРУУЛАХ УНДАА | 109.5 | 105.0 |
| 02.2 ТАМХИ | 110.6 | 105.1 |
| 03. ХУВЦАС, БӨС БАРАА ГУТАЛ | 100.7 | 101.3 |
| 03.1 ХУВЦАС, БӨС БАРАА | 100.9 | 101.7 |
| 03.1.1 ХӨВӨН, БӨС БАРАА | 113.6 | 101.3 |
| 03.1.2 БҮХ ТӨРЛИЙН ХУВЦАС | 99.5 | 101.8 |
| 03.1.3 ЖИЖИГ ЭДЛЭЛ, ХЭРЭГСЭЛ | 102.3 | 100.0 |
| 03.2 ГУТАЛ | 100.4 | 100.4 |
| 04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ | 99.4 | 100.1 |
| 04.1 ОРОН СУУЦНЫ БОДИТ ТҮРЭЭС | 105.4 | 105.4 |
| 04.2 ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 104.2 | 100.0 |
| 04.3 УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| 04.4 ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ | 97.5 | 100.0 |

| Барааны бүлгээр | 2018 II / 2017 II | 2018 II / 2017 XII |
|---|---|---|
| **05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА** | **107.0** | **101.3** |
| 05.1 ГЭР АХУЙН ТАВИЛАГ, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭ | 107.0 | 102.1 |
| 05.2 ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ | 103.0 | 102.1 |
| 05.3 ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА | 101.9 | 100.0 |
| 05.4 ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА | 122.3 | 100.1 |
| 05.5 ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭР | 116.9 | 101.0 |
| 05.6 ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА ГЭРИЙН Б | 104.3 | 101.0 |
| **06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** | **108.4** | **105.9** |
| 06.1 ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙНИ ХЭРЭГСЭЛ | 109.8 | 107.0 |
| 06.2 АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 101.1 | 100.0 |
| 06.3 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| **07. ТЭЭВЭР** | **113.8** | **102.4** |
| 07.1 ТЭЭВРИЙН ХЭРГСЭЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ | 121.8 | 100.0 |
| 07.2 ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ | 107.7 | 107.2 |
| 07.3 ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 75.6 | 100.0 |
| **08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** | **100.0** | **100.0** |
| 08.2 ТЕЛЕФОН АППАРАТ, ФАКСЫН ХЭРЭГСЭЛ | 100.0 | 100.0 |
| 08.3 ТЕЛЕФОН УТАС, ФАКСЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| **09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ** | **104.8** | **101.7** |
| 09.1 ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨ | 101.3 | 100.0 |
| 09.2 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| 09.3 НОМ, СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ | 111.5 | 104.1 |
| **10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ** | **100.3** | **100.0** |
| **11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ** | **98.3** | **100.0** |
| 11.1 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ | 95.6 | 100.0 |
| 11.2 ЗОЧИД БУУДАЛ ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| **12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ** | **107.0** | **100.4** |
| 12.1 ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ | 107.8 | 100.3 |
| 12.3 ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ | 106.2 | 101.1 |
| 12.6 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| 12.7 БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |

# XI. ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

2018.03.12

| Гол нэр төрлийн бүтээгдэхүүн | Хэмжих нэгж | 2017 оны мөн үед | 2018 онд | 2018/2017 хувь |
|---|---|---|---|---|
| Хүрэн нүүрс | мян.тн | 3.8 | 5.5 | 144.7 |
| Жонш | мян.тн | 2.4 | 1.2 | 50.0 |
| Гөлтгөнө | мян.тн | 0.0 | 0.0 | - |
| Дулааны эрчим хүч | мян.гкал | 29.3 | 22.9 | 78.2 |
| Хүснэгт, маягт | х.д.х | 35.6 | 21.7 | 61.0 |
| Талх | тн | 26.3 | 16.2 | 61.6 |
| Нарийн боов | тн | 34.8 | 17.5 | 50.3 |
| Чихэр | тн | 0.9 | 0.6 | 66.7 |
| Архи | мян.л | 6.0 | 5.1 | 85.0 |
| Хиамны зүйл | тн | 0.1 | 0.1 | 100.0 |
| Сүү, тараг | мян.л | 1.1 | 0.7 | 63.6 |
| Хоормог | мян.л | 0.0 | 0.0 | - |
| Ааруул | тн | 0.2 | 0.2 | 100.0 |
| Вакум цонх | $м^2$ | 0.0 | 0.0 | - |
| Вакум хаалга | $м^2$ | 0.0 | 0.0 | - |
| Модон эдлэл | мян.төг | 6204.0 | 8750.0 | 141.0 |
| Түгээсэн цэвэр ус | $мян.т^3$ | 16.5 | 16.0 | 97.0 |
| Сувагжуулалт | $мян.м^3$ | 11.1 | 10.7 | 96.4 |
| Оёдол эсгүүр | мян.төг | 9820.5 | 17520.0 | 178.4 |
| Блок | мян.ш | 0.0 | 0.0 | - |

XII. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ (оны үнээр )

2018.03.12 мян.төг

| Аж үйлдвэрийн салбар | 2017 | 2018 | 2018/2017 хувь |
|---|---|---|---|
| **Нийт дүн** | **1396488.6** | **1298678.3** | **93.0** |
| **Уул уурхайн олборлох аж үйлдвэр** | **140175.8** | **237162.8** | **169.2** |
| Нүүрс олборлолт | 96013.5 | 131577.0 | 137.0 |
| Гөлтгөнө | 0.0 | 0.0 | - |
| Жонш олборлолт | 44162.3 | 105585.8 | 239.1 |
| **Боловсруулах аж үйлдвэр** | **212873.8** | **187399.5** | **88.0** |
| Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл | 194365.7 | 169024.0 | 87.0 |
| Хуснэгт маягт үйлдвэрлэл | 2483.6 | 1517.5 | 61.1 |
| Боловсруулах үйлдвэр бусад | 16024.5 | 16858.0 | 105.2 |
| **Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт,** | **1043439.0** | **874116.0** | **83.8** |
| *Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл* | 945893.3 | 786011.9 | 83.1 |
| Ус ариутгал ус хангамж | 97545.7 | 88104.1 | 90.3 |

XIII. ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээ

2018.03.12

| Хэмжих нэгж | 2017 оны 2 сар | Хэмжих нэгж | 2017 оны 1 сар | 2018 | 2018 |
|---|---|---|---|---|---|
| | | | | 1 р сар | 2 р сар |
| 1. Малын үнэ /мян.төг/ | | | | | |
| Тэмээ | | | | | |
| Нас гүйцсэн | эр | тол | 1,185.7 | 1,103.8 | 1,088.5 |
| | эм | тол | 1,004.1 | 920.8 | 923.1 |
| Өсвөр насны | эр | тол | 720.9 | 645.8 | 650.0 |
| | эм | тол | 702.7 | 633.3 | 637.5 |
| Адуу | | | | | |
| Нас гүйцсэн | эр | тол | 894.4 | 736.7 | 739.3 |
| | эм | тол | 878.2 | 639.3 | 625.0 |
| Өсвөр насны | эр | тол | 515.3 | 482.7 | 478.6 |
| | эм | тол | 511.5 | 472.3 | 470.8 |
| Үхэр | | | | | |
| Нутгийн үүлдрийн, нас гүйцсэн | эр | тол | 1,166.6 | 976.7 | 1,026.7 |
| | эм | тол | 1,015.3 | 871.4 | 835.7 |
| Өсвөр насны | эр | тол | 705.9 | 603.6 | 596.4 |
| | эм | тол | 637.1 | 589.3 | 571.4 |
| Нас гүйцсэн хонь | эр | тол | 140.7 | 137.3 | 134.0 |
| | эм | тол | 90.8 | 97.9 | 93.2 |
| Нас гүйцсэн ямаа | эр | тол | 103.5 | 131.3 | 94.3 |
| | эм | тол | 70.7 | 95.4 | 72.1 |
| 2.Малын гаралтай бүтээгдэхүүний | | | | | |
| Тэмээний ноос | | кг | - | - | - |
| Ямааны ноолуур | | кг | - | - | 70.0 |
| Тэмээний шир | | ш | 17.0 | 18.0 | 20.0 |
| Адууны шир | | ш | 32.0 | 20.0 | 20.0 |
| -2 м-ээс доош хэмжээтэй үхрийн шир | | ш | 20.0 | 25.0 | 25.0 |
| -2 м- ээс дээш хэмжээтэй үхрийн шир | | ш | 30.0 | 30.0 | 30.0 |
| Хонины ноостой, өлөн гэдэстэй арьс | | ш | 3.0 | 5.5 | 5.0 |
| Ямааны ноолууртай, өлөнтэй арьс | | ш | 30.0 | 36.0 | 40.0 |

## XIV. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

2018.03.12

| сумд | төрсөн хүүхдийн | | Бүх нас баралт | | 0-1 насны | | 1-5 насны хүүхдийн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 |
| Дэлгэрцогт | 0 | 0 | 1 | 2 | 0 | 1 | 0 | 0 |
| Дэрэн | 0 | 1 | 0 | 2 | 0 | 0 | 0 | 0 |
| Говь-Угтаал | 1 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 |
| Цагаандэлгэр | 0 | 0 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 |
| Баянжаргалан | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Өндөршил | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Гурвансайхан | 1 | 0 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 |
| Өлзийт | 0 | 0 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хулд | 0 | 3 | 2 | 1 | 0 | 0 | 0 | 0 |
| Луус | 0 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 |
| Дэлгэрхангай | 2 | 1 | 7 | 3 | 1 | 0 | 0 | 0 |
| Сайхан-Овоо | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Эрдэнэдалай | 5 | 5 | 4 | 7 | 0 | 0 | 0 | 0 |
| Сайнцагаан | 122 | 138 | 14 | 20 | 1 | 1 | 0 | 2 |
| Адаацаг | 1 | 3 | 3 | 2 | 0 | 0 | 0 | 0 |
| Дүн | 134 | 154 | 39 | 42 | 2 | 2 | 0 | 2 |

## XV. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 2-Р САРЫН ҮНИЙН МЭДЭЭ/аймгаар/

2018.03.12

| | Нэр төрөл | Дундговь | Төв | Өмнөговь | Дорноговь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гурил, дээд зэрэг /Алтантариа/ | 1450.0 | 1400.0 | 1697.0 | 1350.0 |
| 2 | Гурил, 1-р зэрэг /Алтантариа/ | 1200.0 | 1167.0 | 1300.0 | 1100.0 |
| 3 | Гурил, 2-р зэрэг /Алтантариа/ | 875.0 | 933.0 | 1075.0 | 875.0 |
| 4 | Гоймон, /Алтан тариа/, туузан 320 г-тай | 817.0 | 750.0 | 833.0 | 783.0 |
| 5 | Талх, орон нутгийн үйлдвэрийн | 1033.0 | 1200.0 | 1033.0 | 1400.0 |
| 6 | Гурилан боов,0.450г, /аймгийн үйлдвэрийн/ | 1650.0 | 1200.0 | 2267.0 | 1833.0 |
| 7 | Жигнэмэг /Юбилейные 150-180г, цайны/ | 1167.0 | 1267.0 | 1183.0 | 1150.0 |
| 8 | Цагаан будаа, задгай, кг | 2283.0 | 2300.0 | 2267.0 | 2200.0 |
| 9 | Шар будаа, задгай, кг | 1650.0 | 1483.0 | 1800.0 | 1600.0 |
| 10 | Хонины мах, кг | 5500.0 | 5750.0 | 5700.0 | 4333.0 |
| 11 | Адууны мах, кг | 6000.0 | 6500.0 | 6000.0 | 5167.0 |
| 12 | Ямааны мах, кг | 4500.0 | 4500.0 | 4000.0 | 3833.0 |
| 13 | Дотор мах, цувдай, цусгүй | 500.0 | 2250.0 | 2000.0 | 1833.0 |
| 14 | Хиам чанасан, 1кг | 8333.0 | 8333.0 | 9000.0 | 6600.0 |
| 15 | Сүү, задгай, л | 3000.0 | 2000.0 | - | 2000.0 |
| 16 | Сүү савласан,1л. Цэвэр сүү | 2667.0 | 2733.0 | 2533.0 | 2500.0 |
| 17 | Хорхой ааруул, задгай, чихэртэй | 16500.0 | 13333.0 | 15000.0 | 12500.0 |
| 18 | Өндөг,ш,дотоод | 337.0 | 307.0 | 310.0 | 350.0 |
| 19 | Ургамлын тос, 1литр, Кларина | 3400.0 | 4067.0 | 3493.0 | 3133.0 |
| 20 | Өөхөн тос, кг | - | 1500.0 | - | 1500.0 |
| 21 | Шар тос, кг | 10000.0 | 16000.0 | 14000.0 | 15000.0 |
| 22 | Цөцгийн тос, задгай, кг | 3600.0 | 3500.0 | 3933.0 | 3567.0 |
| 23 | Төмс дотоод, кг | 917.0 | 800.0 | 967.0 | 1000.0 |
| 24 | Лууван хятад, кг | 1233.0 | 1500.0 | 1233.0 | 1500.0 |
| 25 | Байцаа хятад, кг | 1650.0 | 1500.0 | 1400.0 | 1600.0 |
| 26 | Сонгино хятад, кг | 1083.0 | 1700.0 | 1200.0 | 1500.0 |
| 27 | Элсэн чихэр, кг, орос | 2000.0 | 2133.0 | 2100.0 | 2000.0 |
| 28 | Хатуу чихэр, орос, кг, /Барбарис/ | 5400.0 | 5500.0 | 5533.0 | 5500.0 |
| 29 | Зөөлөн чихэр, /Мишка/, кг | - | 10000.0 | 9000.0 | 9833.0 |
| 30 | Шоколад, "Alpen gold" | 2167.0 | 2300.0 | 1957.0 | 2033.0 |
| 31 | Давс, цагаан, 1 кг, йоджуулсан | 1000.0 | 1000.0 | 797.0 | 700.0 |
| 32 | Майноз, /Золотой 500г/ | 4700.0 | 4600.0 | 4667.0 | 4467.0 |
| 33 | Кетчуп, 900г, Чили | 2067.0 | 2000.0 | 2040.0 | 1933.0 |
| 34 | Ногоон цай, Stimo, савласан 90г | 1550.0 | 1667.0 | 860.0 | 1017.0 |
| 35 | Байхуу цай, Акбар, 20 ширхэгтэй | 1600.0 | 1667.0 | 1457.0 | 1500.0 |
| 36 | Цагаан архи, 0.5 Ерөөл | 8233.0 | 8167.0 | 7983.0 | 8283.0 |
| 37 | Пиво, "Боргио", 0.5л | 1533.0 | 1500.0 | 1797.0 | 1517.0 |
| 38 | Янжуур тамхи, /West/, саарал | 2333.0 | 2850.0 | 2900.0 | 2733.0 |
| 39 | Янжуур тамхи, /Улаан шонхор/,Монгол тамхи | 2067.0 | 2050.0 | 1800.0 | 1783.0 |
| 40 | Бензин, А-80, 1 литр | 1667.0 | 1543.0 | 1617.0 | 1557.0 |
| 41 | Бензин, А-92, 1 литр | 1790.0 | 1710.0 | 1833.0 | 1737.0 |
| 42 | Дизель түлш, 1 литр | 2127.0 | 2020.0 | 2083.0 | 1767.0 |

XV. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

2018.03.12

| Сумд | Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо | | Бүгд үзлэг | | Халдварт өвчин бүгд | | үүнээс /зарим үзүүлэлтээр/ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сүрьеэ | | вируст гепатит | | тэмбүү | | трихомониаз | |
| | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 |
| Дц | 50 | 46 | 214 | 272 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Дн | 46 | 31 | 418 | 175 | 1 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 1 |
| Гу | 31 | 40 | 847 | 471 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Цд | 31 | 26 | 491 | 355 | 5 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бж | 45 | 41 | 408 | 611 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Өш | 80 | 56 | 944 | 620 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |
| Гс | 39 | 29 | 420 | 466 | 3 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Өт | 33 | 20 | 653 | 541 | 3 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 3 | 1 | 0 | 0 |
| Хд | 40 | 37 | 487 | 521 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Лс | 34 | 45 | 649 | 591 | 5 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 3 | 1 | 0 |
| Дх | 34 | 29 | 970 | 518 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Со | 43 | 33 | 746 | 387 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 |
| Эд | 149 | 145 | 2348 | 1812 | 11 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 1 |
| Ад | 52 | 56 | 1951 | 1154 | 1 | 2 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Сц | 967 | 1050 | 19000 | 16678 | 44 | 62 | 3 | 4 | 1 | 2 | 2 | 8 | 8 | 11 |
| Мд | 79 | 84 | 96 | 93 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Эб | 70 | 47 | 59 | 43 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| МУЭ төв | 136 | 161 | 411 | 314 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| ДҮН | 1959 | 1976 | 31112 | 25622 | 77 | 74 | 4 | 5 | 1 | 2 | 6 | 14 | 11 | 13 |

* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

# XVI. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ

| | Үзүүлэлт | 2017 | 2018 | 17/16 хувь |
|---|---|---|---|---|
| | Оны эхний 18 ба түүнээс дээш насны хүний тоо | 30086 | 30528 | 101.5 |
| | Бүх хэрэг | 43 | 43 | 100.0 |
| Хэргийн өнгө | Хүн амины хэрэг | 0 | 1 | 0.0 |
| | Хүчингийн хэрэг | 0 | 1 | 0.0 |
| | Золгүй учрал | 1 | 0 | 0.0 |
| | Дээрмийн хэрэг | 1 | 0 | 0.0 |
| | Булаалт | 0 | 0 | 0.0 |
| | Танхайн хэрэг | 1 | 0 | 0.0 |
| | Бусдын бие махбодид гэмтэл учруулах | 19 | 18 | 94.7 |
| | Бусдын өмчийн хулгай | 16 | 11 | 68.8 |
| | Малын хулгай | 13 | 3 | 0.0 |
| | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг | 2 | 6 | 300.0 |
| | Ашиглалын хэрэг | 0 | 0 | 0.0 |
| | Залилангийн хэрэг | 0 | 3 | 0.0 |
| | Албан тушаал | 0 | 0 | 0.0 |
| | Гал түймэр | 0 | 0 | 0.0 |
| | Бусад | 4 | 1 | 25.0 |
| нөхцөл | Согтуугаар | 6 | 3 | 50.0 |
| | Бүлэглэж | 2 | 0 | 0.0 |
| | НХХ ээс | 0 | 0 | 0.0 |
| | Илрээгүй хэрэг | 10 | 37 | 370.0 |
| | Гэр бүлийн хүчирхийллийн улмаас | 2 | 4 | 200.0 |
| хэргийн ангилал | Хөнгөн | 27 | 33 | 122.2 |
| | Хүндэвтэр | 14 | 0 | 0.0 |
| | Хүнд | 2 | 10 | 0.0 |
| | Онц хүнд | 0 | 0 | 0.0 |
| | Гэмт хэрэгт холбогдогсод | 39 | 5 | 12.8 |
| | Учирсан бүх хохирол /сая.төг/ | 92.1 | 86.8 | 94.2 |
| | Нөхөн төлүүлсэн хохирол /сая.төг/ | 63.9 | 4.2 | 6.6 |
| | Илрүүлэлтийн хувь | 63.0 | 11.9 | 18.9 |

# XVII.ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ

2018.03.12

| сум | 18 ба түүнээс дээш насны хүн | 18 -аас дээш насны 10000 хүнд ногдох | Бүх хэрэг | Холбогдогч | Хохирол /мян.төг/ | Золгүй учрал | Хүн амь | хүчин | дээрэм | булаалт | танхай | бусдын бие махбодьд гэмтэл учруулсан | бусдын өмчийн хулгай | малын хулгай | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын | гал түймэр | албан тушаал | Залилан | бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дэлгэрцогт | 1106 | 9 | 1 | | | | | | | | | | | | 1 | | | | |
| Дэрэн | 1363 | 7 | 1 | | 3000.0 | | | | | | | | | | 1 | | | | |
| Говь-Угтаал | 1068 | 0 | 2 | | 5800.0 | | | | | | | | | 1 | | | | | 1 |
| Цагаандэлгэр | 694 | 0 | 0 | | | | | | | | | | | | | | | | |
| Баянжаргалан | 756 | 0 | 1 | | 1000.0 | | | | | | | 1 | | | | | | | |
| Өндөршил | 973 | 10 | 1 | | 3500.0 | | | | | | | 1 | | | | | | | |
| Гурвансайхан | 1449 | 7 | 2 | 1 | 11500.0 | | 1 | | | | | 1 | | | | | | | |
| Өлзийт | 1607 | 0 | 1 | | 3000.0 | | | | | | | 1 | | | | | | | |
| Хулд | 1612 | 0 | 1 | | 17000.0 | | | | | | | 1 | | | | | | | |
| Луус | 1239 | 0 | 1 | | 1800.0 | | | | | | | | | 1 | | | | | |
| Дэлгэрхангай | 1489 | 0 | 0 | | | | | | | | | | | | | | | | |
| Сайхан-Овоо | 1470 | 0 | 1 | | 500.0 | | | | | | | 1 | | | | | | | |
| Эрдэнэдалай | 3685 | 3 | 0 | | | | | | | | | | | | | | | | |
| Сайнцагаан | 10074 | 18 | 31 | 3 | 38654.0 | 1 | | 1 | 1 | | | 13 | 8 | 1 | 3 | | | 3 | |
| Адаацаг | 1943 | 5 | 0 | | 1000.0 | | | | | | | | | | | | | | |
| Бусад | 0 | 0 | | 1 | | | | | | | | | | | | | | | |
| Бүгд | 30528 | 8 | 43 | 5 | 86754 | 1 | 1 | 1 | 1 | 0 | 0 | 19 | 8 | 3 | 5 | 0 | 0 | 3 | 1 |